

СОЁМБОМЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.06.07. №69 (69)

ҮЙЛ ЯВДАЛ

Г.Сайханбаяр: ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТАЙВАН ЦАГТ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ УЛАМ БҮР НЭМЭГДЭЖ БАЙНА

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр өнгөрсөн баасан гарагт Зэвсэгт хүчний 013, 150, 017 дугаар ангиудад ажиллалаа. Түүнийг дагалдан Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа С.Ганбямба, Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ нар ажилласан юм.

Батлан хамгаалахын сайдыг ангиудын хүндэт харуул ёслол төгөлдөр угтан авсны дараа түүнд дээрх ангиудын танилцуулга, үйл ажиллагааны төлөвлөгөө, цэргийн сургалт бэлтгэлийн явц, алба хаагчдын сахилга дэг журам, шийдвэрлэх шаардлагатай, тулгамдаж буй асуудлуудын талаар тус ангиудын захирагч нар танилцуулсан юм.

Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн хувьд судалгаа хийгдэж бэлэн болсон төслүүд, ангийн алсын хараа, цаашдын зорилго, зорилтууд, "Радио электроникийн туршилт судалгааны төв"-ийн үйл ажиллагаа болон Цэргийн холбоо үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд хийгдэх бүтээлч ажлуудын талаар танилцуулсны дараа насжилт өндөртэй ангийн барилга, объектуудад "Цэргийн хотхоны стантарт"-ын дагуу их засвар хийж, өнгө үзэмжийг нь сайжруулах, албан тушаалын орон сууцны шинээр барьж байгуулах саналтай байгааг уламжилсан юм. Харин Зэвсэгт хүчний 150 дугаар анги өнгөрсөн хугацаанд ангийн барилга, байгууламжуудад хийсэн тохижилт, засварын ажлууд, үндсэн үүрэг зориулалт, түүхэн замнал, ангиас төрсөн алдартнуудын талаар танилцуулж ангийн бие бүрэлдэхүүнд хүрэлцээгүй спорт заал, цэргийн гал тогоо, хичээлийн танхим барихаас гадна ангийн үндсэн дансанд бүртгэлтэй зарим нэгж, техникүүдийг нөхөн хангуулах асуудлыг шийдвэрлүүлэх саналтай байгааг илэрхийлэв. Хамгийн сүүлд Зэвсэгт хүчний 017 дугаар анги тайван цагийн бүтээн байгуулалтад хэрхэн оролцдог талаар дурдаж, 2020 оны бүтээн байгуулалтад оролцсон байдал, 2021 онд ямар ажлыг хийж, бүтээх талаар товч танилцуулсан юм. Харин ангийн дансанд байгаа боловч биетээр байхгүй техникүүд болон зарим тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлүүлж



барилгачдын цалин, албан тушаалын орон сууц, ангийн байрлалд хамаарагдах газрын маргаан, туслах үйлдвэрийн барилгыг барих, Зэвсэгт хүчний хэмжээнд баригдаж буй барилга, байгууламжийн зарим төрлийн материалыг үйлдвэрлэн нийлүүлэхэд дэмжлэг авах хүсэлтэй байгааг уламжилж байв. Ангийн захирагч нарын танилцуулсан санал, хүсэлтийн хариуд аль болох шийдвэрлэх боломжтой асуудлуудаас эхлэн шат дараатайгаар ажлаа эхлүүлэх болно гэдгийг салбарын сайдын зүгээс хэлж байлаа.

Үүний дараа Батлан хамгаалахын сайд дээрх ангиудын алба хаагч нартай уулзалт зохион байгуулсан юм. Энэ үер тэрээр "Монгол Улсын Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин энэ онд 100 насны босгоо давж байна. Энэ хүрээнд олон бүтээлч ажлыг хийж, хэрэгжүүлсэн. Энэ

цаг дор миний бие болон та бүхэн энэ салбарын түүхийг бүтээлцэж, ирэх зууны бодлогыг тодорхойлох хувь тохиож байна гэдгийг хэлэх таатай байна. Өнгөрсөн хугацаанд цар тахлаас үүдэн Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудад ажиллаж чадаагүй. Би энэ салбарт ажиллаж байсан цэргийн мэргэжлийн хүний хувьд анги, байгууллагуудын үндсэн үйл ажиллагааг маш сайн мэддэг хэдий ч офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчид маань ямар нөхцөлд алба хааж, амьдарч байгаатай өөрийн биеэр танилцах зайлшгүй шаардлагатай гэж үзэн бүх ангиудтай танилцах төлөвлөгөөтэй байгаа. Энэ хүрээнд Зэвсэгт хүчний хэмжээнд шинэчлэл хийх үүднээс олон зорилтуудын дэвшүүлэн ажиллаж байна. Манай салбар улс орны тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдалд том

үндсэн чиг үүргийг хүлээсэн. Тиймээс энэ салбар хууль, эрх зүйн шинэчлэлүүдийг үргэлжлүүлэн хийх хэрэгцээ, шаардлага байсаар байна. Тэр тусмаа Монгол Улсын Зэвсэгт хүчний тайван цагт хүлээх үүрэг улам бүр нэмэгдэж байна. Зөвхөн дотооддоо ард түмнийхээ аюулгүй байдлыг хангадаг байсан бол дэлхийн энх тайвны төлөө хилийн чанадад үүрэг гүйцэтгэж эхэлснээс хойш 20 орчим жил өнгөрсөн. Үүгээр дамжуулж үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолоо улам бүр бэхжүүлж байгаа. Одоо Монгол Улсын Зэвсэгт хүчин хөгжлийнхөө үе шатыг эхлүүлж байна. Үүнд алба хаагчид та бүхний оролцоо маш их юм шүү" хэмээж нийт бие бүрэлдэхүүнд хандан цаашдын ажил, хөдөлмөрт нь өндөр амжилтыг хүсэн ерөөлөө.

Дэслэгч Т.ИДЭР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
6	2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
33	23

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
35	19

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.401.00	3.507.00
CNY	443.00	446.90
RUB	38.10	40.20
JPY	25.41	26.27
KRW	2.44	2.63

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 27
2021.06.07.
/ДАВАА ГАРАГ/

ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН МОГОЙ САРЫН ГУРВАН ХӨХ УЛААН НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:
Өлзийтэй сайн.

Наран ургах, шингэх:
04.54-20.48

Барилдлага:
Үхэх

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Суудал:
Мод

Аргын тооллын 6 сарын 7, Сумъяа гараг. Билгийн тооллын 27, Гос хүүхэн одтой, улаан нохой өдөр. Өдрийн наран 4 цаг 54 минутад мандан, 20 цаг 48 минутад жаргана. тухайн өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн. Эл өдөр үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал адеуус муулах, лус тахих, хүүхэд үрчлэн авах, гэр байшингийн суурь тавихад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзитэй сайн.

ЗЭВСЭГТ ХҮЧНЭЭС ХӨДӨЛМӨРИЙН БААТАР, ГАВЬЯТ БАРИЛГАЧИН, ЭМЧ, ТЭЭВЭРЧИД ТӨРЛӨӨ

Монгол орны стратегийн өндөр ач холбогдолтой төмөр замыг богино хугацаанд барих ажлыг удирдан, амжилттай хэрэгжүүлэх ажлыг манлайлсан мөн халдварт цар тахалтай тэмцэх ажилд онцгой үүрэг гүйцэтгэсэн зэргийг үнэлэн өнгөрсөн бямба гарагт Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга, дэд хурандаа Д.Жаргалсайханд Хөдөлмөрийн баатар, Зэвсэгт хүчний 7781 дүгээр ангийн захирагч, хошууч генерал Пүрэвийн Доржсүрэн, Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын орлогч дарга, хурандаа Цэгмэдийн Ганхөлөг, Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын ахлах мэргэжилтэн, хурандаа Батсуурийн Энхбаяр нарт Гавьяат барилгачин, Зэвсэгт хүчний 7780 дугаар ангийн ачаа тээврийн бүлгийн жолооч, ахлах ахлагч Борчулууны Мөнхтөрд Гавьяат тээвэрчин цол хүртээлээ.

Мөн Цэргийн төв эмнэлгийн орлогч дарга, хурандаа Галхүүгийн Наранхүү Гавьяат эмч, Цэргийн төв эмнэлгийн дарга, ерөнхий эмч Сүхбаатарын Батболд, Цэргийн төв эмнэлгийн сувлагч Агваансодовын Сольхүү нар Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээсэн бол Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга асан, бригадын генерал Монтойн Хүрлээг Сүхбаатарын одонгоор шагнасан юм.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

65.266

ЭДГЭРСЭН

53.780

НАС БАРСАН

311/14

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2690 (37)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

261

ЭДГЭРСЭН

2390

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 172,242,495

Эдгэрсэн

Нийт: 149,900,649

Нас барсан

Нийт: 3,709,397

ТАНДАЛТ

ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 19,753	3,380,812
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/ СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 7,501	2,993,959
ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 4,420	451,318
ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 1,096	87,100

2021.06.06
11:00 ЦАГИЙН БАЙДЛААР

ХАРИУЦАГ
ДАВНА

ЦАХИМ ШУУДАНД

"ХААНЫ ЭРЭЛД-2021" СУРГУУЛИЙН ТӨГСГӨЛИЙН ШАТНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХУРАЛ ЯВАГДАЖ БАЙНА



Монгол Улс, АНУ-ын Зэвсэгт хүчний хамтран зохион байгуулдаг "Хааны эрэлд-2021" олон улсын энхийг сахиулах ажиллагааны сургуулийн төгсгөлийн шатны төлөвлөлтийн хурал Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж байна. Анхан болон дунд шатны төлөвлөлтийн хурлууд цар тахлын нөхцөл байдлаас үүдэн цахим хэлбэрээр явагдсан бөгөөд энэ удаа өмнөх шатны хурлаар яригдсан асуудлуудыг нарийвчлан хэлэлцэж, шийдвэрлэх юм.

Төлөвлөлтийн хуралд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Энхийг

дэмжих ажиллагааны хэлтэс, Эрүүл мэндийн хэлтэс, Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв болон АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, АНУ-ын Энэтхэг-Номхон далайн цэргийн командлалын Хуурай замын цэргийн командлал, Аляскийн Үндэсний гвард, "Олон Улсын Аюулгүй байдал засаглалын институт" зэрэг байгууллагын төлөөлөл оролцож байна. Төлөвлөлтийн хурал 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдөр өндөрлөнө.

Хошууч Т.МӨНГӨНШАТАР



ЭРҮҮЛ МЭНДИЙНХЭЭ ТӨЛӨӨ ГҮЙЦГЭЭЕ!

"Дасгал хөдөлгөөн хийцгээе" идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяныг улс орон даяар 06 дугаар сарын 02-ноос 30-ны өдрүүдэд зохион байгуулж байна. Тус аянд Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, ахлагч нар болон цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчид нэгдэн 6 дугаар сарын 5-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд "Дасгал хөдөлгөөн хийцгээе" арга хэмжээг Нийслэлийн спортын хороотой хамтран зохион байгууллаа.

Аяны хугацаанд бүх бие бүрэлдэхүүн Strava.app ашиглан "Нутгийн захиргааны гүйгчид 2021" клубт нэгдэж, идэвхтэй алхалт хийж, өглөө бүр гүйж, нийт туулсан замын км, бусад үзүүлэлтийг дундын цахим бүлэгтээ 0 мэдээлэн ажиллах юм. Аяны хүрээнд дугуй унах, иог, дасгал хийх, Төрийн албан хаагчдад өдрийн цагаар 1,2 дугаар 16 тоот дасгалыг хийж хэвшүүлэхээр төлөвлөжээ.

Ахлах дэслэгч Б.БАТЦЭЦЭГ

БИЗНЕС ТӨСӨЛ БИЧИХ АРГА ЗҮЙН СУРГАЛТ БОЛОВ

ҮБХИС

Багшийн хөгжлийн төвөөс хувь хүний чадамжийг дээшлүүлэх ажлын хүрээнд аливааг бүтээлчээр сэтгэх, шинэ санааг илэрхийлэх, бодит ажил хэрэг болгох үүднээс төсөл бичиж сурах, төслийн баримт бичиг боловсруулах, судалгаа, шинжилгээ тооцоолол хийх, тайлагнах арга зүйн мэдлэг олгох зорилгоор "Төсөл бичих арга зүй"-н сургалтыг онлайнгаар Microsoft teams программ ашиглан зохион байгуулав.

Уг сургалтад АБДС-ийн ЭЗМТ-ийн багш Д.Нямхүү сургагч багшаар ажиллаж, ҮБХИС-ийн харьяаллын дээд сургууль, коллеж, төв, тэнхимийг төлөөлж 16 багш оролцсон юм. Оролцогчид энэ үеэр 3 төслийн багт хуваагдаж хүүхэд хөгжлийн төв байгуулах



төсөл, инновацын нэгдсэн лаборатори байгуулах төсөл, хүлэмж байгуулах төслүүдийг боловсруулснаар төсөл бичих чадварыг эзэмшив. Үүнээс гадна өөрсдийн боловсруулсан 1 төсөлтэй болж төгсөж байгаа

нь цаашид хэрэгжүүлэх боломжтой гарц, гаргалгаа, хэрэгжилтийг биелүүлэхээр зорих зорилго, зорилт өмнөө тавьцаасан практик ач холбогдолтой сургалт болсноороо онцлог байлаа.

ЗУРГАА ДАХЬ ӨДРИЙН ГҮЙЛТ 208 КМ-ЭЭС ЭХЭЛЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамц Ховдоос Улаанбаатар хот хүртэл 1500 км зайд гүйхээр 2021 оны зургаадугаар сарын 2-ны өдөр гараанаас гарсан. Тэрбээр урд шөнө Ховд аймгийн Дарви сумын нутагт ирсэн бөгөөд өнөөдөр өглөөний гүйлт 208 км эхэлж байгаа аж.

Э.Даваажамц гурван сарын хугацаанд бэлтгэл хийсэн бөгөөд өдөрт 40-45 км гүйснээр долоодугаар сарын 10-ны өдөр буюу Монгол Улсын Төрийн далбааны өдөрт зориулсан цэргийн ёслолын жагсаалын үеэр Улаанбаатар хот, Сүхбаатарын талбайд барианд орохоор тооцолсон байна. Тэрээр энэ гүйлтээ Монгол Улсад Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жил, Ховд аймаг байгуулагдсаны 90 жилийн ой, ирэх жил буюу 2022 онд тохиох Ардын Хатанбаатар Магсаржавын



нэрэмжит Зэвсэгт хүчний 123 дугаар анги байгуулагдсаны 100 жилийн ойд зориулж байгаа аж.

ХҮҮХДИЙН ТОГЛООМЫН ТАЛБАЙГ ТОХИЖУУЛЛАА



Зэвсэгт хүчний 234 дүгээр анги

Ангийн эцэг, эхийн зөвлөлөөс санаачлан Хүүхэд бүхнийг эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих, тоглох наадах тэгш боломжийг хангах, "Цулхарын

хүүхдийн тоглоом"-ын 280 м2 талбайг жишиг тоглоомын талбай болгон тохижууллаа.

Тус тоглоомын талбайн 10 дугаар сард нээлтийн үйл ажиллагааг хийх юм. Нийтийн эзэмшил хүүхдийн тоглоомын талбайг

тохижуулах, засварлах ажлыг 2021 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн бөгөөд 280 м2 талбайг хашаажуулан хаягдал дугуйг ашиглан тоглоомууд хийж будаж, сэргээн засвар үйлчилгээ хийж, богино хугацаанд амжилттай ажиллалаа.

Хүүхдийн талбайн засвар үйлчилгээ хийхэд ангийн удирдлага, ахмад дайчид, хамт олны тусламж дэмжлэгээр богино хугацаанд амжилттай тохижуулсан юм.

Цаашид сум орон нутгийн ард иргэдээ уриалан стандарт тоглоомууд авч, мод тарих зэрэг "Эко цэцэрлэгт хүрээлэн" болгон тохижуулахаар ажиллаж байна.

Ч. ОЮУНЧИМЭГ

Спорт

"АЛДАР" СПОРТ ХОРОО ТЭРГҮҮН БАЙР ЭЗЛЭВ



Өнгөрсөн баасан гарагт Монголын дугуйн холбооны "Засмал замын" улирлын нээлтийн тэмцээн Төв аймгийн Алтанбулаг сумын замд болж өндөрлөлөө. Мэргэжлийн болон сонирхогчдын гэсэн нийт 15 байгууллагын 140 орчим тамирчин бүх насны ангилалд өрсөлдсөнөөс насанд хүрэгчдийн эмэгтэй ангилалд, ОУХМ Ц.Солонго, насанд хүрэгчдийн эрэгтэй ангилалд, ОУХМ С.Жамбалжамц U23 насны ангилалд, СМастер С.Аюуш-очир, СМастер Д.Эрхэс, СМастер Б.Амарболд нар тус тус тэргүүн байруудад шалгарсан амжилт үзүүлэв.

Байгууллагын дүнгээр Батлан хамгаалах яамны харьяа Зэвсэгт хүчний Алдар Спорт Хороо дугуйн баг тэргүүн байр эзэллээ.